



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/239

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Шинэ суурьшлын бүсэд цахилгааны эх үүсвэр татах (Рашаант сум, Нарлаг хороолол) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Арвилах” ХХК-тай 160,709,295 (нэг зуун жаран сая долоон зуун есөн мянга хоёр зуун ерэн тав) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Арвилах” ХХК-ийн захирал (Г.Очирсүрэн)-д үүрэг болгосугай.

3.Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Рашаант сумын Засаг дарга (Б.Жавзмаа)-д даалгасугай.

4.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



04 Аймгийн Засаг даргын 2025 оны
 дугаар сарын 15-ны/ний өдрийн
 А/239 дугаар захирамжийн хавсралт

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	2 790 576	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	2 790 576	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	1 395 288	Ү.Бямбасүрэн
4	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 60 хоног	Ү.Бямбасүрэн
5	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Батцогт
6	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Д.Батцогт Ү.Бямбасүрэн
7	Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь	Д.Батцогт Ү.Бямбасүрэн